


Ардчиллын талаар монголчууд ямар ойлголттой байдаг болон энэ талаар хариулт өгч чадаж буй байдлыг 2003, 2006 оны судалгааны дүнгээр харьцуулан үзүүлэв. “Танд ардчилал гэхэд юу ойлгогддог вэ? Гурав хүртэл хариулт өгнө үү” гэж нээлттэй хариулт авах асуултын дүнгээс үзэхэд гурван хариулт бүрэн өгч чадах хувь бараг 10 хувиар буурсаны зэрэгцээ ерөөс хариулж чадахгүй хувь гурваар өссөн байна.



Респондентын өгсөн бүх хариултыг нэгтгэн кодлож үзэхэд 2006 онд 2003 оныхоос байдал бараг өөрчлөгдөөгүй бөгөөд Эрх чөлөө/Чөлөөт байдал, Тэгш байдал/Шудрага ёс, Хийсвэр эерэг ойлголт давамгайлсаар байна. Харин ийнхүү нэгтгэн кодлоход Мэдэхгүй эсвэл ямар нэгэн Хариулт өгч чадахгүй гэсэн ангилалд багтах хувь 2006 онд 2003 онтой харьцуулахад 5,5 хувиар нэмэгджээ.

Ардчиллын талаархи ойлголтын төвшнийг ангилж үзэхдээ ардчиллыг бодит хэрэгжиж буй үйл явц (procedural understanding) эсвэл утга агуулгын (substantive understanding) ойлголт гэж хуваадаг. Энэ арга зүйг баримтлан монголчуудын хувьд эдгээрээс аль нь давамгайлж буйг эндээс харж болно. Бүхэлдээ монголчуудын ардчиллын талаархи ойлголтонд ерөнхий үзэл санаа, философи нь давамгайлсаар байгаа ба харин бодит үйл явц, институтжилтын ойлголт маш бага байна.

